

21. Аав аа, шийдвэр гаргах эрх мэдэлтэй хүмүүст мэргэн ухааныг өгч, Эсватинигийн эдийн засгийг сэргээгээч. Ард иргэд нь ажлын байртай, бүх нийтээрээ хангалуун боломжтой байх болтугай. (Сур. 3:5-6)

22. Бурхан минь, Африк дахь сүм чуулган дээр хаант улсаа байгуулах эрх мэдэлийг өгөөч. Таны хаанчлал энэ улсад ирэх болтугай; таны хүсэл энэ газар биелэх болтугай. (Мат. 6:10)

23. Бид тахлын үед хорио цээрийн дэглэмд байгаа өндөр настнуудын төлөө залбирч байна. Тэднийг мартаж болохгүй, харин гэр бүл, найз нөхдийнхөө айлчлалаар урам зоригтой байх болтугай. (Мат. 25:36)

24. Аав аа, Өмнөд Африкт бусдын төлөө үнэнчээр өмгөөлж хамгаалдаг, таны төлөө үнэнч байдаг хүмүүсийн хэрэгцээг хангаж өгөөч. (Дуу. 23)

25. Хүчтэй борооны улмаас газар нутаг нь сүйдсэн Малави улсын төлөө бид залбирч байна. Ард түмэн таныг тусламж гуйн дуудаж байгаа тул хоргодох байраар хангаж, аюулгүй газар нь болоорой. (Дуу. 46:1)

26. Эзэн минь, Зимбабвегийн олон газарыг сэргээн засварлах шаардлагатай байна. Удирдагчид эдийн засаг, боловсрол, эрүүл мэндийн тогтолцоогоо сэргээхийг танаас хүсэх болтугай. (Иер. 33:3)

27. Сургуулийн амралт, улирлын амралтын үеэр эцэг эх нь ажил дээрээ байх үед өөрсдийгөө болон бие биедээ анхаарал тавих ёстой хүүхэд, өсвөр насныхныг хамгаалаарай. (Дуу. 121:7)

28. TWR Найдвар доторх Эмэгтэйчүүдийн үйл ажиллагаа нь Африкийн зарим оронд буруу харилцааны улмаас зогсонги байдалд орж байна. Хүмүүс хоорондоо ойлгомжтой, үнэн зөв харилцдаг болоосой. (Кол. 4:6)

29. Аав аа, Африк эмэгтэйчүүд хоол тэжээлийн дутагдал, бичиг үсэг үл мэдэх, ажилгүйдэл, хүүхдийн эндэгдэл, ядуурал, хүчирхийлэл, нөөцийн хомстолд өртөж байгаа тул тэднийг тэтгэж, хүчирхэгжүүлээрэй. (Флп. 4:6)

30. Амралтын үеэр Өмнөд Африкийн олон гэр бүл асрамжийн газрын хүүхдүүдэд гэр орноо нээж өгөөсэй гэж бид залбирч байна. (Мат. 25:35)

31. Бурхан минь, ХДХВ/ДОХ-ын гутаан доромжлолыг тээж яваа Малави эмэгтэйчүүд таны дүрд бүтээгдсэн үнэ цэнэтэй охид болж харагдах болтугай. (Эх. 1:27)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



**2022. 5.**

**Өмнөд Африкийн төлөөх залбирал**

Дэлхийн хоёр дахь том тив болох Африк тивд 54 улс, 3000 үндэстэн, 1 тэр бум хоёр зуун сая хүн амтай олон соёл, олон үндэстэн зэрэгцэн оршдог. Ажилгүйдэл, ядуурал, өсвөр насны жирэмслэлт зэрэг олон хүмүүсийн тулгамдсан асуудал бий. Ялангуяа ганц бие эмэгтэйчүүд халтварт өвчин гарсанаас хойш олон бэрхшээлүүдтэй тулгарах болсон. Африк эмэгтэйчүүдийн төлөө залбирч өгөхийг хүсч байна.

**TWR Korea 북방선교방송**

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층  
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Мозамбикийг дайрсан хар салхины улмаас олон хүүхэд, эмэгтэйчүүд орон гэргүй болсон билээ. Бурхан минь ээ, Бүх зүйлээ алдсан хүмүүст хэрэгцээтэй бүхнээр нь хангаж, шаардлагатай бүхнийг өгөөч! (Дуу. 46:1)

2. Аав аа, бид Зимбабве улсын парламентын гишүүд, цагдаа, цэрэг, арми, шүүхийн удирдагуудийг Их Эзэн таниас эмээдэг удирдагчууд байгаасай гэж хүсэж байна. Тэд таны зөвт байдал, шударга ёсыг хүлээн авч, улс эх орноо хөгжүүлсэн, ард түмнээ хайрласан удирдагчид байх болтугай. (Дуу. 119:1–2)

3. Аав аа, таны нэрэн доор эхнэр, нөхрүүд гэрлэлтээ батлуулах ёстой билээ. Мадагаскарын ард түмэнд үүнийг ойлгуулж, гэрлэлтээ эв нэгдэлтэй, бат бэх байлгахын тулд танруу хандах ёстой гэдгийг тэдэнд ойлгуулаач. (Эх. 2:24)

4. Малави дахь TWR "Найдвар доторх Эмэгтэйчүүд" залбирлын бүлгийн гишүүд танд хандан тууштай залбирч байгаа билээ. Тэд гэр бүл, сүм цуглаан, улс орны эдийн засгийн хөгжилдөө хувь нэмрээ оруулахыг хүсэж байна. Тэдэнд бизнес эрхлэх мэргэн ухаан, нөхцөл боломжийг олгооч. (Дуу. 20:1–2)

5. Бурхан минь ээ, сайн мэдээг тань номлож, таны үгийг бусдад хуваалцахын тулд Лесото руу илгээлтийн хүмүүсийг явуулаач. Хүмүүс таныг болон үнэн үгийг тань чанга атгаж амьдралаа өөрчилж, сэргэлт авч босох болтугай гэж хүсэж байна. (Дуу. 97:3)

6. Эзэн минь, бид Эсватини дахь улс төрийн тогтвортой байдлын төлөө залбирч байна. Тэндхийн хүмүүс таны амар амгалан дотор алхаж, удирдагчид нь таниас зүг чиг хайх болтугай. (Лев. 26:6)

7. Аав аа, бие махбодын хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлан гадуурхалтад өртсөн хүмүүсийг аварч, эдгээгээч. Таны сайн мэдээ асуудалтай амьдралыг нэг нэгээр нь өөрчлөх болтугай. (Дуу. 12:5–8)

8. Эзэн минь, тахлын үед бизнесүүд нь хаагдаж ядуу зүдүү үлдсэн Өмнөд Африкийн гэр бүлүүдийг ажилтай болгож, тэдэнд бизнесээ дахин эхлүүлэх итгэл найдварыг өгөөч. (Дуу. 113:7)

9. Эзэн минь, Зимбабвегийн ард түмний зүрх сэтгэлд үндэсний эдгэрэл, эвлэрэл, энх тайван, шударга ёсыг газар нутагт нь авчрахын төлөө та ажиллаач! (Дуу. 127:1)

10. Аав аа, Малави дахь эрчүүд аливаа асуудлыг аюулгүй арга замаар зөв аргаар шийдэх болтугай. Амиа хорлож, үр хүүхдээ цөхрөлд үлдээж байгаа эрчүүдийн хараалыг таслаач. (Дуу. 23:4)

11. Царт тахлын үед хичээлээ хийхэд хүндрэлтэй байсан, сургуульд тогтмол хамрагдаагүй оюутнуудад нигүүлсэл, амар амгалан, хичээлээ нөхөж сурах хүч чадал мэргэн оюун ухааныг өгөөч. (Флп. 4:7)

12. Эзэн минь, Африкийн эмэгтэйчүүдийг ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хайхрамжгүй эрчүүдээс хамгаалаач. Тэдэнд сэтгэл санааны болон бие махбодын эдгэрэлтийг авчираач. (Египетээс гарсан. 15:26)

13. Аав аа, Эсватини дахь сүмээ сэрээж, энэ улс даяар сэргэлтийг авчираач. Итгэгчид бусдын өмнө болон таны хаанчлал дотор амьдрах амьдралаа нэгдүгээрт тавих болтугай. (Мат. 5:16)

14. Эзэн минь, Африкийн ард түмэнд эдгэрэлтийг авчираач. Олон хүмүүс өнгөрсөн амьдралдаа тохиолдсон бэрхшээлээс болж уурлаж цөхөрч

байна. Тэдний зүрх сэтгэлийг Өөрийн үнэн үгээр эдгээж, амар амгаланг авчираач. (Дуу. 30:10–11)

15. Лесотогийн эмэгтэйчүүдтэй ихэвчлэн ямарч хүндлэлгүй харьцдаг билээ, Эзэн минь. Ард түмэндээ эмэгтэйчүүдийн үнэ цэнийг олж харахад нь тусалж ойлгуулж өгөөч, тэдэнд анхаарал халамж тавьж, амьдралд нь хүйсийн тэгш боломжоор хангаарай. (Гал. 3:28)

16. Эзэн минь, Африкт хүүхэд худалдаалах гэмт хэргийг таслан зогсоож, энэ муу зүйлд өртсөн хүүхдүүдийг аварч, эдгээгээч. Эдгээр хүүхдүүдийг хүчирхийлж байгаа хүмүүсийн зүрх сэтгэлийг яллаж шийтгэж ухааруулж өгөөч Бурхан минь. (Дуу. 5:11)

17. Эзэн минь, Өмнөд Африк дахь манай TWR-ийн “Найдвар доторх Эмэгтэйчүүд”-ийн сайн дурын гишүүдийн гэр бүл, санхүүгийн асуудлыг анхаарч үзээч. Залбирлын хуанли орчуулах тал дээр сайн ажилласанд нь бид талархаж байна. (Дуу. 121:8)

18. Эзэн минь, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстол нь ялангуяа Малави дахь бэлэвсэн эхнэр, өнчин хүүхдүүдэд хэцүү байна. Эдийн засгийн хямралдаа тогтвортой байдлыг авчрахад удирдагчуудыг нь та удирдан чиглүүлээрэй. (Флп. 4:19)

19. Аав аа, Зимбабвегийн ард түмний зүрх сэтгэл, оюун ухааныг сэргээгээч. Таны үнэн, энх тайван, шударга ёс ард түмэн, нийт нийгмийг өөрчлөх болтугай. (Дуу. 20:7)

20. Бурхан минь, Африкийн олон эрчүүдийн архинд донтсон гинжийг таслаач. Тэд танаас бүрэн эрх чөлөөг олж, Таныг Эзэн хэмээн хүлээн зөвшөөрч дагах болтугай. (Дуу. 107:19–20)